

Гааль ба амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ сэдэвт Монгол Улсад зориулсан цуврал вебинар

Цуврал 1: Хилийн нэгдсэн удирдлага болон ургамал, амьтан,
тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээний
туршлага

2022 оны 6 дугаар сарын 16-17

Хэсэг 2: Ариун цэврийн болон ургамлын эрүүл ахуйн (SPS) агентлагуудын
бүрэн эрх

Профессор Роб Блэк, Багийн Ахлагч, Техникийн туслалцаа 9500
Азийн Хөгжлийн Банк



ТА 9500: Худалдааг хөнгөвчлөх ариун цэврийн болон ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг шинэчлэх , БНХАУ-ын Ядуурлыг бууруулах, бүс нутгийн хамтын ажиллагааны сан, Бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийн сангаас хамтран санхүүжүүлдэг.

Ариун цэврийн болон ургамлын эрүүл ахуйн (SPS) агентлагуудын бүрэн эрх

Танилцуулгын агуулга

- ▶ *SPS хэлэлцээрийн тухай ойлголтыг сэргээн санах (Танилцуулах уулзалтаар яригдсан)*
- ▶ Ургамал хамгааллын олон улсын конвенци (УХОУК) ба Үндэсний ургамал хамгааллын байгууллагын бүрэн эрх
- ▶ Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагын (ДМАЭМБ) газрын амьтны эрүүл мэндийн Кодексийн 3.4 Бүлэг ба мал эмнэлгийн үйлчилгээний чиг үүрэг
- ▶ Асуулт & Хариулт

Дагалдах материалууд

- ▶ SPS Хэлэлцээр (Англи хэл, Орос хэл)
- ▶ Ургамал хамгааллын олон улсын конвенци (Англи хэл, Орос хэл)
- ▶ ДМАЭМБ (ОIE) Газрын амьтны эрүүл мэндийн кодекс
БҮлэг 3.4.3

(Кодексийн албан бус орчуулга Орос хэл дээр байдаг)

ЭРҮҮЛ АХУЙ, УРГАМЛЫН ЭРҮҮЛ АХУЙН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

‘SPS Хэлэлцээр’ (Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр)

- ▶ Дэлхийн Худалдааны байгууллага (ДХБ) 1995 онд танилцуулсан
- ▶ Хөдөө аж ахуйн болон байгалийн нөөцийн гаралтай барааны олон улсын худалдааны норматив хүрээ (журам)-г зааж өгдөг
- ▶ Хүнсний аюулгүй байдал, мал эмнэлгийн арга хэмжээ, ургамлын эрүүл ахуйн асуудлыг хамардаг
- ▶ ДХБ-ын хувьд эдгээр эрүүл ахуй болон ургамлын эрүүл ахуйн арга хэмжээнүүд нь бүхэлдээ Тарифын бус (ТБ) арга хэмжээнүүд юм
- ▶ Товчхондоо, *SPS Хэлэлцээр нь* худалдаанд шударга бусаар саад учруулж буй SPS –ийн арга хэмжээнээс сэргийлэх журам юм.
- ▶ SPS-ийн арга хэмжээг эрсдлийн үнэлгээнд эсвэл олон улсын стандартад суурилж үндэслэлийг гаргана.

Юуг Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээнд тооцдог вэ?

SPS хэлэлцээрийн А хавсралтаас

- ▶ Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ гэдэгт эцсийн бүтээгдэхүүний шалгуур, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, туршилт, хяналт шалгалт, гэрчилгээ олголт, батлалтын ажиллагаа, амьтан, ургамал тээвэрлэх, эсхүл тээвэрлэлтийн явцад тэдгээрийг тэжээх, арчлахтай холбогдсон аливаа шаардлагыг агуулсан эрүүл ахуйн журам, статистикийн холбогдох арга, загвар сонгон авалт, эрсдлийг үнэлэх аргад хамаарах заалт, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд шууд хамаарах баглаа боодол, хаяг шошгоны тухай шаардлага зэргийг оролцуулсан холбогдох бүх төрлийн хууль, тогтоол, журам, шаардлага, хэм хэмжээ багтана.
- ▶ ДХБ-ын Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээрээр Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ эсвэл Техникийн дүрэм хоорондын ялгааг хянан шийдвэрлэдэг.

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИ

Ургамал хамгааллын олон улсын конвенци (УХОУК)



IPPC and the
International Year
of Plant Health

Ургамал хамгааллын олон улсын конвенцийн 1997 оны хувилбар нь Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн хүрээнд ургамлын эрүүл ахуйн хэм хэмжээ болон зарчмуудыг зааж өгсөн байдаг.

- ▶ Хамгийн чухал 2 зарчим нь:
 - ▶ ‘Эрх бүхий байгууллагын’ хувиар SPS хэлэлцээрийн хүрээнд ургамлын эрүүл ахуйн асуудлыг хариуцсан Ургамал хамгааллын үндэсний байгууллага (УХҮБ)-ыг байгуулах, **үйл ажиллагааг нь тодорхойлох**
 - ▶ Зөвхөн **зохицуулалт бүхий хортон шавжийг** ургамлын эрүүл ахуйн арга хэмжээнд хамруулж болох юм
 - ▶ *Хорио цээртэй шавж ба зохицуулалттай хорио цээрийн бус шавж*

Хортон шавжийн эрсдлийн үнэлгээг УХАБ хэрхэн ашиглах вэ?

УХҮБ нь хортон шавжийн эрсдэлийн шинжилгээг (ХШЭҮ) ашиглан зохицуулалттай хортон шавьж, ургамалын хорио цээрийн импортын шаардлагыг тодорхойлж, хилийн бүх хяналт, хилийн дараах үйл ажиллагааг шалган нягтлахад ашигладаг.

Хортон шавжийн жагсаалт, барааны эрсдэлийн ангилал зэрэг арга хэмжээг боловсруулах нь хилийн хяналт шалгалтын явцад шийдвэр гаргахаас ялгаатай нь бодлогод тулгуурлаж хийгддэг. УХҮБ нь хилийн хяналт шалгалт, улс доторх арга хэмжээний дүрэм журмыг УХҮБ-ны өөрийн эсвэл шилжүүлэн хүлээн авсан эрх мэдлийн дагуу тогтоох ёстой.

УХҮБ-н үүрэг хариуцлага

УХОУК-ийн IV бүлгээс хураангуйлав

- ▶ Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ олгох, экспортын илгээмжийн аюулгүй байдлыг хангах
- ▶ Хортон шавьжийн эрсдлийн шинжилгээ
- ▶ Импортын хяналт шалгалт
- ▶ Мананцаржуулах зэрэг хорио цээрийн боловсруулалтыг хэрэглэх
- ▶ Хилийн дараах үйл ажиллагаа
 - ▶ Тандалт
 - ▶ Хортон шавьж бүхий газрыг тодорхойлж, хамгаалах,
 - ▶ Хортон шавьжгүй газар, хортон шавьжийн тархалт багатай газар
- ▶ Ажилтныг сургах, хөгжүүлэх

Эдгээр чиг үүргүүдийн аль нэгийг нь бусад байгууллагад шилжүүлж болох боловч үндсэн үүрэг хариуцлагыг УХҮБ хариуцна



Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний олон улсын стандарт (ISPMs)

- ▶ Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх стандарт ('хортон шавжийн стандарт' БИШ)
- ▶ Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний олон улсын стандартыг анхдагч хуулиар хүлээн зөвшөөрч, хоёрдогч хуулиар зохицуулдаг
- ▶ АХБ-ны зүгээс юун түрүүн Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний олон улсын 6 стандартыг зөвлөж байна:
 - ▶ *ISPM 6 Тандалт*
 - ▶ *ISPM 11 Хортон шавжийн эрсдлийн үнэлгээ ба хорио цээрт шавж*
 - ▶ *ISPM 12 Ургамал, хорио цээрийн гэрчилгээ*
 - ▶ *ISPM 19 Зохицуулалтай шавжийн эрсдлийн удирдамж*
 - ▶ *ISPM 20 Ургамал, хорио цээрийн импортын зохицуулалтын системийн удирдамж*
- ▶ Сүүлийн үед ISPM 32 (Бараа бүтээгдэхүүнийг эрсдлийн дагуу ангилах) худалдааг хөнгөвчлөхөд их чухал болж ирж байгаа

Ургамлын эрүүл ахуй, хорио цээр ба ургамал хамгаалал

- ▶ УХОУК-ийн албан ёсны бичвэр нь орос хэл дээр - МЕЖДУНАРОДНАЯ КОНВЕНЦИЯ_ПО КАРАНТИНУ И ЗАЩИТЕ РАСТЕНИЙ – Англи хэл дээр International Convention on quarantine and protection of plants гэж байдаг. (<https://www.ippc.int/en/core-activities/governance/convention-text/>)
- ▶ Яагаад Конвенци гэдэг нэрийг сольсон бэ?
- ▶ Ургамлын хорио цээр ба дотоодын ургамал хамгаалал нь хуучин ЗХУ-д хууль тогтоомж, захиргааны хувьд ихэвчлэн тусдаа байсан. CAREC-ийн зарим орнуудад энэ хэвээр байна
- ▶ CAREC-ийн SPS-ийн арга хэмжээг шинэчлэх нэгдсэн төслөөр дамжуулан хэрэгжүүлж буй АХБ-ны бодлого нь Ургамал хамгаалал, хорио цээрийн асуудлыг хууль тогтоомж, захиргааны хувьд нэгдмэл болгоход оршино. “Ургамлын эрүүл мэнд” нь дотоод ургамал хамгаалал, худалдааны арга хэмжээнд хамаарах SPS-ийн салбар юм

Хилийн хяналтыг гаалийн хяналттай нэгтгэх нь

CAREC-ийн зарим улсуудын хувьд эхэндээ салбар хоорондын интеграцчилал (хүнсний аюулгүй байдал, мал эмнэлэг болон ургамлын эрүүл ахуйн) хамран хийгдсэний дараа Гаалийн байгууллагатай нэгтгэсэн ➔




Дараах асуултууд гарч ирнэ:

- ▶ УХҮБ нь хяналтын байгууллагуудын дунд ямар байр сууринд байх вэ (Монгол улсын хувьд ГЕГ)?
- ▶ Ямар байгууллага эсвэл байгууллагууд дараах асуудлуудыг хариуцах вэ:
 - ▶ Экспорт/ рэ-экспортын хорио цээрийн гэрчилгээ олгох?
 - ▶ Хорио цээрийн шаардлагатай Хортон шавжийг илрүүлэх эрсдлийн үнэлгээ болон ургамлын хорио цээрийн импортын шаардлагатай холбоотой бодлогын холбоотой ажлууд?
 - ▶ Хортон шавжийн ангилал?
 - ▶ Хил нэвтэрсний дараах арга хэмжээ (тандалт, хортон шавжгүй нутаг, хортон шавж тархах, тэдгээрийг устгах?)

Сүүлд хэлэлцэнэ. Монгол улсын ургамал хамгааллын хууль тогтоомжинд авч үзэх арга хэмжээнүүдийн талаар 3-р хэсэгт авч үзнэ.

Худалдааг хөнгөвчлөх хүрээнд CAREC-ийн бүсийн хилийн хяналтын ажиллагаанд хийгдсэн хувьсал

(Хялбаршуулахын тулд, мал эмнэлгийн хяналтыг тусад нь байлгахгаар тооцоолж байна)




ДМАЭМБ-ЫН КОДЕКС ДАХ МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНД

Transboundary animal diseases (TADs)

Амьтдыг малын халдварт өвчин, хүмүүсийг зоонозын өвчнөөс хамгаалахын тулд ДМАЭМБ * газрын амьтны эрүүл мэндийн кодексээр нь олон улсын худалдаанд амьд амьтдын (үрийн шингэн, өндгөн эс, үр хөврөл, эдийн өсгөвөр зэрэг) -р болон хоол хүнс болон амьтны гаралтай бусад бүтээгдэхүүнээр дамжин халдварлаж болох хил дамнасан малын өвчлөлийг (TAD) тодорхойлж, жагсаалтыг гаргасан байдаг.

* ДМАЭМБ (хуучин OIE гэж товчилдог байсан)

- ▶ Хил дамнасан малын өвчлөлийн жагсаалтын шаардлагыг Кодексийн 1,2-р бүлэгт харин өвчний жагсаалтыг өвчлөмтгий малын төрлөөр нь 1,3 бүлэгт оруулсан байдаг.



Үндэсний мал эмнэлгийн алба нь мал, амьтны эрүүл мэндийг хариуцсан эрх бүхий байгууллага

Мал эмнэлгийн хууль тогтоомжийн норматив зохицуулалтыг ДМАЭМБ/ОIE-н **газрын амьтны эрүүл мэндийн кодексийн 3.4-т заасан** байдаг. 3.4.3-т Мал эмнэлгийн үндэсний хууль тогтоомж ямар зарчмыг үндэслэх ёстойг заасан.

Хамгийн чухал нь:

Эрх бүхий төрийн байгууллага нь хуулиар эрх олгогдсон байх ба мал эмнэлгийн нийтийн эрүүл мэндийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж чадахуйцаар зохион байгуулагдсан байх ёстой.

Мал эмнэлгийн асуудал, хууль тогтоомжийн нарийн төвөгтэй байдлыг хүлээн зөвшөөрч, нэгээс олон эрх бүхий байгууллага байж болох ч "өөр өөр байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааны найдвартай тогтолцоог бий болгох ёстой" (3.4.5-р зүйл)

Үндэсний мал эмнэлгийн албаны эрх, үүргийн хүрээ

- ▶ Мал эмнэлгийн асуудал нь ургамлын эрүүл мэндийн асуудалтай харьцуулахад илүү төвөгтэй байдаг, учир нь мал эмнэлгийн байгууллагууд хил дээр болон зах зээл дээр **малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг** шалгах, амьд малын эрүүл мэндийг сахин хамгаалахад оролцдог.
- ▶ Тэд амьд амьтантай харьцаж буй **байгууллага, байр, амьтны гаралтай бүтээгдэхүүн, ялангуяа нядалгааны газруудын эрүүл ахуйн хяналтыг хариуцаж** болно. Иймээс амьтдын тавлаг байдлыг мөн ДМАЭМБ-ын кодексийн дагуу хариуцдаг бол малын гаралтай бүтээгдэхүүний хувьд хүнсний аюулгүй байдлын эрх бүхий байгууллагатай уялдаа холбоотой ажиллах ёстой.
- ▶ Малын эмч нар зохицуулалттай мал эмнэлгийн эмийн жор бичиж, эм олгож болох юм
- ▶ Эцэст нь хэлэхэд, мал эмнэлгийн хяналт нь юуны түрүүнд эмнэлгийн мэргэжилтнүүдтэй дүйцэхүйц урт, эрчимтэй сургалтанд хамрагдсан мэргэшсэн малын эмч нарын үүрэг юм. Зарим чиг үүргийг тэдний удирдлаган дор бага эмч нарт шилжүүлж болно.

Танилцуулгын дараа Монголын мал эмнэлгийн алба ГЕГ-тай хэрхэн уялдаж байгаа талаар ярилцах боломжтой

Мал эмнэлгийн хууль тогтоомжийг үндэсний хууль эрх зүйтэй нэгтгэх зарчмуудын хураангуй

- ▶ Эрх бүхий байгууллагыг байгуулах
- ▶ Эрх бүхий байгууллагад шаардлагатай эрхийг өгөх
- ▶ Эрх бүхий байгууллагын эрхийг шилжүүлэх
- ▶ Малын эмч, малын бага эмч ба тэдгээрийн зохицуулалт
- ▶ Мал эмнэлгийн салбарын лабораторууд
- ▶ Мал амьтны эрүүл мэнд ба өвчний хяналт. Үүнд:
 - ▶ мал амьтны ялган тэмдэглэх, мөшгилт, мал амьтны нөхөн үржихүй
 - ▶ Малын тэжээл
 - ▶ өвчний тандалт, урьдчилан сэргийлэлт, хяналт
- ▶ Мал амьтны тавлаг байдал
- ▶ Мал эмнэлгийн эм, био бэлдмэл



Монгол улсын хууль эрх зүйн хүрээнд эдгээр асуудлуудыг хэрхэн авч үздэгийг 4-р Хэсэгт хэлэлцэнэ.

Хэлэлцүүлэг, дараа нь Асуулт & Хариулт

Баярлалаа!